



ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00000834

Огноо:	2022-02-24	Дансны дугаар	Дүн /тоогоор/
Төлөгч:	Диспетчерийн үндэсний төв ХХК	Дебит	6,383,069.00
Төлөгчийн:	Худалдаа Хөгжлийн Банк	406002860	
Хүлээн авагч:	Өнө мөнхийн түшиг ХХК	Кредит	
Хүлээн авагчийн:	Голомт Банк	1105411326	
Мөнгөний дүн тоогоор (үсгээр)	6,383,069.00 хоногийн . . . хувийн торгууль . . .	
(Зургаан сая гурван зуун наян гурван мянга жаран есөн төгрөг 00 мөнгө)	 төгрөг мөнгө	
Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн:	Дагалдах баримтын №		Дүн (торгуулийн хамт)
	Огноо: 2022-02-24		****
Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр)	22/2022-Хурлын заалны т/т-ийн газардуулах байгууламжид холбох цахилгааны шит самбар угсарч АВР-тай самбарт холбох гэрээт ажлын төлбөр рд:2699877		Гүйлгээний утга (Төлбөрийн зориулалт)
Тамга	Гүйцэтгэх захирал: <i>Т. Валентин</i>	Банкинд гүйлгээ хийсэн	Төлөх хугацаа
	Ерөнхий нягтлан бодогч: <i>[Signature]</i> оны . . . сарын . . .	Төлбөрийн ээлж
		Хангалттай салбар	
		(тэмдэг, гарын үсэг)	
		Төлөр №04	



БАТЛАВ:
ДИСПЕЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


/Г.БАЛЖИННЯМ/

БАТЛАВ:
“ӨНӨ МӨНХИЙН ТҮШИГ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


/П.ӨНӨМӨНХ/

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 02-р сарын 19-ны өдөр

№22/2022

Улаанбаатар хот

Нэг талаас Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/ ТӨХХК /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Захиргаа удирдлагын албаны дарга Б.Биндэръяа, нөгөө талаас “Өнө мөнхийн түшиг” ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/, түүнийг төлөөлж Захирал ажилтай П.Өнөмөнх /хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний тухай хуулийг удирдлага болгон ДҮТ ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны дугаар А/05 тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2022 оны 02-р сарын 18-ний өдөр Захиалагчид ирүүлсэн “Хурлын тэмдэглэл-03”-ийг үндэслэн Талууд дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэ ГЭРЭЭГ байгуулав.

1. НИЙТЛЭГ ЗААЛТ

- 1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн баталсан ажлын даалгаврын дагуу “Хурлын заалны тоног төхөөрөмжүүдийн газардуулах байгууламжид холбох, цахилгааны ЦИТ самбарын өрөөнд сэлгэн залгагчтай оруулгын самбар угсарч АВР-тай самбарт холбох солих” ажлыг хугацаанд нь гүйцэтгэж захиалагчийн өмчлөл буюу эзэмшилд шилжүүлнэ.
- 1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.
- 2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа 7 хоног
- 2.3. Ажил эхлэх хугацаа 2022-02-19
- 2.4. Ажил дуусах хугацаа 2022-02-26

3. АЖЛЫН ХӨЛС

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 6,383,069.00 /Зургаан сая гурван зуун наян гурван мянга жаран ес/ төгрөг байна. Үнэд НӨАТ орсон болно.
- 3.2. Ажлын үр дүнг бүрэн гүйцэтгэж, түүнийг хүлээлгэн өгөх акт үйлдэж өгсний дараа бүрэн төлнө.

4. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгнө.
- 4.2. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.
- 4.3. Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.

5. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.2. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
- 5.3. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

6. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,05 хувийн алданги төлнө.
- 6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.3. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

7. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

8. БУСАД ЗААЛТ

- 8.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээг 3 хувь үйлдэж, захиалагч тал 2, гүйцэтгэгч тал 1 хувийг авна.
- 8.3. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 8.4. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**ЗАХИЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ДИСПЕТЧЕР

_____/Б.БААТАР/
ЗУА-ИЙН ДАРГА

_____/Б.БИНДЭРЪЯА/
СЭЗА-НИЙ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ

НЯГТЛАН БОДОГЧ
_____/Т.БЯМБАЖАВ/
ХУУЛЬЧ

_____/Б.АНХЗАЯА/
ЗУА-НЫ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН
_____/Э.ӨЛЗИЙМАНДАХ/
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

_____/С.НАМЧИНДОРЖ/
МЭРГЭЖИЛТЭН

ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот 17060 Хан-уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн Өргөн чөлөө Засгийн газрын XIV байр 4,5 давхар
Утас: 7004 1371, 91177701
Факс: 7004 3467
Мэйл хаяг: Namchindorj.s@ndc.energy.mn

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ЗАХИРАЛ**

_____/П.ӨНӨМӨНХ/
МОНГОЛ УЛААНБААТАР ХОТ
ӨНӨ
МОНХИЙН ТҮШИГ
ХХК
117249901 6227031 АН700126

ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол, 856, 46 тоот,
Утас: +976 95119901
РД: 6227031
Банк: Голомт банк
Данс: 1105411326
Имэйл: unumunkhtushig@gmail.com

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

№22/2022

Улаанбаатар хот

Нэг. Гэрээ, гэрээний талууд

- 1.1. Гэрээний нэр, дугаар, огноо: “Хурлын заалны тоног төхөөрөмжүүдийн газардуулах байгууламжид холбох, цахилгааны ЦИТ самбарын өрөөнд сэлгэн залгагчтай оруулгын самбар угсарч АВР-тай самбарт холбох” ажил гүйцэтгэх гэрээ, №22/2022, 2022-02-19
- 1.2. Диспетчерийн үндэсний төв ХХК /ДҮТ ХХК/, Өнө мөнхийн түшиг ХХК хооронд 2022 оны 02 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан “Хурлын заалны тоног төхөөрөмжүүдийн газардуулах байгууламжид холбох, цахилгааны ЦИТ самбарын өрөөнд сэлгэн залгагчтай оруулгын самбар угсарч АВР-тай самбарт холбох” ажил гүйцэтгэх гэрээт ажлыг 2022-02-22-ний өдрийн Гүйцэтгэх захирлын А/49 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022-02-26 өдрийн шийдвэрийг үндэслэн ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгэсэн тул Талууд энэ гэрээг дүгнэсэн актыг үйлдэв.
- 1.3. Гэрээнд заасан ажлыг хүлээн авсан ажлын хэсэг:

Захиалагчийг төлөөлж:

Ажлын хэсгийн дарга
Гүйцэтгэгчийг төлөөлж:

Б.Ганбат ТДА-ны дарга
П.Өнөмөнх Захирал

Хоёр. Төлбөр тооцоо

- 2.1. Энэ гэрээний нийт үнэ нь **6,383,069.00 /Зургаан сая гурван зуун наян гурван мянга жаран ес/** төгрөг байна. Энэ үнэд НӨАТ орсон болно.
- 2.2. Гэрээгээр гүйцэтгэх ажлыг бүрэн гүйцэтгэсэн тул Талууд бүрэн хүлээн зөвшөөрч төлбөрийг гүйцэтгэгчийн ирүүлсэн нэхэмжлэх болон гэрээний гүйцэтгэлийг дүгнэсэн энэ актыг үндэслэн нийлүүлэгчийн харилцах Голомт банкны 1105411326 тоот дансанд бүрэн шилжүүлнэ.


Гурав. Дүгнэлт

- 3.1. Өнө мөнхийн түшиг ХХК нь Захиалагчид гэрээгээр гүйцэтгэх ажлыг бүрэн хийж, 2022 оны 02 дугаар сарын 23-ний өдөр төлбөрийн нэхэмжлэлийг ирүүлсэн.
- 3.2. **ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ:** “Хурлын заалны тоног төхөөрөмжүүдийн газардуулах байгууламжид холбох, цахилгааны ЦИТ самбарын өрөөнд сэлгэн залгагчтай оруулгын самбар угсарч АВР-тай самбарт холбох” гэрээний гүйцэтгэлийг Талууд 100 хувь гэж дүгнэсэн тул төлбөрийг шилжүүлэх нь зүйтэй болно.


ЗАХИАЛАГЧ:


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 /Г.БАЛЖИННЯМ/
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ
ДИСПЕТЧЕР

 /Б.БААТАР/
ЗУА-ИЙН ДАРГА

 /Б.БИНДЭРЪЯА/
СЭЗА-ИЙН ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 /Т.БЯМБАЖАВ/
ХУУЛЬЧ

 /Б.АНХЗАЯА/
ЗУА-НЫ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 /Э.ӨЛЗИЙМАНДАХ/
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 /С.НАМЧИНДОРЖ/
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ГҮЙЦЭТГЭГЧ:

ЗАХИРАЛ

 /П.ӨНӨМӨНХ/




ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 10/45

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, 25 дугаар зүйлийн 25.1, 26 дугаар зүйл, 68 дугаар зүйлийн 68.1, Хөрөнгө оруулалт, их ба урсгал засвар, техник зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэх, хяналт тавих, санхүүжүүлэх нэгдсэн журмын 2 дугаар бүлгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын 14-р байрны хурлын заалны тоног төхөөрөмжүүдийг газардуулах байгууламжид холбох, цахилгаан цит самбарын өрөөнд сэлгэн залгагчтай оруулгын самбар угсарч АВР-тай самбарт холбох” гэрээт ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Ганбат

ТДА-ны дарга

Гишүүд:

Д.Нацагдорж

МХА-ны Холбоо, мэдээллийн системийн ахлах инженер

Х.Ерөөлт

РХАА-ны Эх үүсгүүрийн реле хамгаалалтын инженер

Б.Лхагвадорж

ЗУА-ны Нийтлэг үйлчилгээний мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Ганцэцэг

СЭЗА-ны Нярав

2. “Засгийн газрын 14-р байрны хурлын заалны тоног төхөөрөмжүүдийг газардуулах байгууламжид холбох, цахилгаан цит самбарын өрөөнд сэлгэн залгагчтай оруулгын самбар угсарч АВР-тай самбарт холбох” гэрээт ажлуудыг хүлээн авах ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан тоо хэмжээ, техникийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт тавьж, шалгаж хүлээн авах ажлыг гэрээний хугацаанд зохион байгуулахыг ажлын хэсэг /Б.Баатар/-т, санхүүгийн баримтад үндэслэн хөрөнгөд бүртгэхийг Санхүү эдийн засгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Т.Бямбажав/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын албаны дарга /Б.Биндэръяа/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БАЛЖИННЯМ